

БАТЛАВ:

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ.....Д.ОЮУНЦЭЦЭГ

**2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 7 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН  
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

ХУГАЦАА: 60МИН

ХУВИЛБАР А

НИЙТ ОНОО 20

7.....ангийн .....овогтой ..... сурагч

**ЭХИЙГ УНШИЖ ОЙЛГООД, ДААЛГАВРЫГ ГҮЙЦЭТГЭНЭ ҮҮ.**

**Нацагдорж минь ийм хүн байлаа./хөрөг найруулал/**

Нөхөр Нацагдоржийг хувьсгалаас өмнө зүс таних төдий явсаар 1921 оны долдугаар сард бие тулж танилцсан юм. ...Нөхөр Нацагдорж бие нарийхан,нуруу тэгш шулуухан ,царай цагаан,үс хөмсөг хар,цочмог харсан хүнд хялардуу юм уу гэмээр,ажиглавал тийм биш,нүдний цагаан их,зовхи нимгэн бөгөөд гар хуруу цэвэр гоолиг,царайлаг залуу байсан юм. Монгол дээл голдуу өмсөх боловч мөн Европ хувцас холимог хэрэглэдэг.Жишээлбэл зангиатай цамцны дээр монгол дээл өмсөж явна.Савхин гутал өмсөнө.Тэр үед ардын намын малгай гэж нэрлэж байсан ногоон хилэн малгай амсөнө.Хааяа тоорцог өмсөнө.Сүүлийн үед үргэлж бүрх малгай өмсөж явах болсон.Бас цэргийн хувцас хааяа өмсөнө.Тэгж явахдаа хувцас нь цэвэр бөгөөд ямар хувцас боловч биедээ тохирсныг эдэлнэ...

Нөхөр Нацагдорж зан ааш дөлгөөн даруу,үг цөөн,үерхэг нөхөрсөг,хүнийг хүндэтгэх нь дуурайлтай ,ихэрхэг бардам зан огт байхгүй ,энгийн ярих буюу хурал дээр үг хэлэхийн өмнө нүдээ дээш харж бодлого тавьж байгаад ярихдаа удаан болгоомжтой,бодлоготой,оновчтой цөөхөн үгээр санал шүүмжлэлээ тавих бөгөөд ер илүү сул үг хэлэхгүй.

1. Эхийн гол санааг тодорхойлон бичээрэй /2 оноо/

.....  
.....

2. "...бодлого тавьж байгаад ярих.." гэдэг нь ямар утгатай үг болохыг тайлбарлан бичээрэй. /2 оноо/

.....  
.....

3. Зохиолч, яруу найрагч Д.Нацагдорж ямар хүн бэ? Өөрийн үзэл бодлыг хоёроос доошгүй өгүүлбэрээр илэрхийлэн бичээрэй./2оноо/

.....  
.....  
.....

4. Эхээс тэмдэг нэрийг түүж бичнэ үү. /2оноо/

.....  
.....

5. 6.Эхээс гадаад шинжийг тоочин бичсэн үг,өгүүлбэрийг олж бичнэ үү./2оноо/


.....  
.....

6. “Мэддэгт мэргэн цоохор

Мэддэггүйд эрээн цоохор” хэмээх санааг илэрхийлэх зохиол аль нь вэ? Зөвийг сонгоорой.

- A. Л.Түдэв “Эрээн цоохорын туурь”
- B. Б.Ринчен “Шүхэрч Буниая” туур
- C. Ц.Түмэнбаяр “Цагаан сүүний домог” туурь
- D. П.Пүрэвсүрэн “Бурханбогд аав хоёр” өгүүллэг

7. Дараах бичил эхийг кирилл бичигт хөрвүүлэн бичээрэй./5оноо/



БАТЛАВ:

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ.....Д.ОЮУНЦЭЦЭГ

**2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 7 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

ХУГАЦАА: 60 МИН

ХУВИЛБАР Б

НИЙТ ОНОО 20

7 ..... ангийн .....овогтой ..... сурагч

**Нөхрөө харж бие зас**

Хүн итгэсэн нөхөртөө л бэрхшээлээ тоочдог юм.Найз нөхдийнхөө зовлон тоочихыг тэсвэртэйгээр сонс. Тэгвэл түүний зовлон нимгэрч, сэтгэл нь уужирч байгааг царайны өнгө, дууны аялгаас нь чи аяндаа мэдэрнэ. Ингэснээр чи нөхрийнхөө давчуурсан сэтгэлийг сайн тэлж өгнө. Найз нөхөдтэйгээ чин сэтгэлээсээ харьцаж бай. Үнэнээрээ байх гоё. Худлаа инээснээс, үнэнээсээ уурлачих нь хавьгүй дээр. Ямар ч үед янз бүрийн авир гарган жүжиглэх хэрэггүй. Байдгаараа байх нь чамайг чимнэ. Хэн нэгэнд тал өгч хуурмаг инээснээс танихгүй хүн шиг дуугүй яв."Бялангачдыг найз нөхөд гэж тооцохоос болгоомжил. Шулуун шударга хүн л жинхэнэ найз нөхөд байдаг юм. Олон найз нөхөдтэй байх сайхан. Гэхдээ тарвалзаж явахад дагах нь олон, тартагтаа тулахад түших нь цөөн байдгийг бодоорой. Бодож, бүтэж, болгож, бүтээж яваа нөхдөөсөө үлгэр ав.

**1. Ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаас үгийн утгыг тайлбарлана уу? /2оноо/**

Бялангач.....

.....

Тал өгөх-.....

.....

**2. Эхийг үйл явдлын тоочимж болохыг 3 шинжээр нь батлаарай./2оноо/**

.....

.....

.....

**3. Хүн итгэсэн нөхөртөө л бэрхшээлээ тоочдог юм.гэсэн нийлмэл өгүүлбэрийг энгийн өгүүлбэр болгоорой. /2оноо/**

.....

.....

.....

.....

4. "Бялангачдыг найз нөхөд гэж тооцохоос болгоомжил.Шулуун шударга хүн л жинхэнэ найз нөхөд байдаг юм.Олон найз нөхөдтэй байх сайхан.Гэхдээ тарвалзаж явахад дагах нь олон, тартагтаа тулахад түших нь цөөн байдгийг бодоорой.Бодож, бүтэж, болгож, бүтээж яваа нөхдөөсөө үлгэр ав. Гэсэн эхийн хэсгээс дараах үгсийн аймгийн үгийг ялган түүгээрэй. /2оноо/

Тэмдэг нэр.....

Тооны нэр.....

Үйл үг.....

5. Дараах үгэнд -ээс 4 нөхцөлийг залгах зөв бичгийн дүрмийг тайлбарлана уу? /2оноо/

Инээснээс.....

Тооцохоос.....

6. Дараах зохиолын нэрийг зохиолчийн нэртээ зөв харгалзуулаарай. /5оноо/

- |                              |                |
|------------------------------|----------------|
| 1.Шүхэрч буनिया              | А.Л.Түдэв      |
| 2.Эрээн цоохор               | б.Б.Ринчен     |
| 3.Цагаан сүүний домог        | С.Ц.Түмэнбаяр  |
| 4.Нутаг гүйсэн унаганы дууль | Д.П.Пүрэвсүрэн |
| 5.Бурханбогд аав хоёр        | Е.Г.Мэнд-Ооёо  |

A.1a.2c.3d 4b 5e

B.1b 2a 3c 4e 5d

C.5c 4a 1d 2e 3b

D.3a 4b 5c 1e 2d

E.4d 2b1c 3e 5a

7. Уншаад кирилл бичигт буулгаарай. /5 оноо/

